



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2023/05-НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАН  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Л.ЧОЙЖЖАНЦАН  
ТАНАА

2023.03.24 № 150

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хайрхан сумын засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Сумын төсвийн орлогын төлөвлөгөө 78.2 хувьтай буюу нийт дүнгээр 101,231.3 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дээрх зөрчлүүд нь бидний тооцсон материаллагийн хэмжээнээс хэтэрсэн, аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогыг сумын төсөвт төвлөрүүлдэг болсон байна.

### Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 79.6 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМААА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	844,471.1	568,680.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	348,816.3	167,192.6
33	АВЛАГА	279,178.1	326,203.6
35	БАРАА МАТЕРИАЛ	216,476.7	75,284.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,670,460.4	2,245,520.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,670,460.4	2,245,520.4
39200	Биет хөрөнгө	6,566,172.4	2,223,240.4
39300	Биет бус хөрөнгө	104,288.0	22,280.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,514,931.5	2,814,200.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	193.6	8,401.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	193.6	8,401.7
41300	Өглөг	193.6	8,401.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,514,737.9	2,805,799.1
51	Засгийн газрын хувь оролцоо	7,514,737.9	2,805,799.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,730,402.3	450,071.4
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,730,402.3	450,071.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,619,228.2	1,808,395.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,165,107.4	547,332.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,514,931.5	2,814,200.8

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,561,417.4	1,847,202.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	286,659.1	389,631.0
110	Орлогын албан татвар	106,074.2	243,012.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	106,074.2	242,993.6
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	18.9
113	Хөрөнгийн албан татвар	143,885.2	90,170.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,699.7	56,448.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	530,224.5	533,262.9
120	Нийтлэг татварын бус орлого	508,316.5	533,262.9
122	Тусламжийн орлого	21,908.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,744,533.8	924,308.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,219,902.3	1,678,939.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,129,360.5	1,320,641.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,204,168.6	1,251,565.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,841,645.6	350,537.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,625.7	43,918.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,138.1	475,858.3
2104	Хангамж, бараа материалын зардал	95,930.8	23,647.1
2105	Нормативт зардал	369,578.4	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,798.9	5,263.2
2107	Томилолт, зочны зардал	2,476.0	3,083.2

**Архангай аймгийн Хайрхан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,911.0	96,867.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	331,064.0	252,390.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	925,191.9	69,075.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	90,541.8	358,298.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	341,515.1	168,263.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	4,820,591.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	341,515.1	-4,652,327.3

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,144,769.9	1,564,152.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	286,659.1	389,631.0
110	Орлогын албан татвар	106,074.2	243,342.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	106,074.2	243,323.5
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	18.9
113	Хөрөнгийн албан татвар	143,885.2	89,840.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,699.7	56,448.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,772.1	22,406.4
1181	Газрын төлбөр	3,155.6	15,700.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	20,772.0	18,342.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,868.2	250,212.5
120	Нийтлэг татварын бус орлого	142,868.2	250,212.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,715,242.6	924,308.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,690,435.0	1,173,128.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,690,435.0	1,173,128.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,764,487.8	1,104,102.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,838,067.5	377,436.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	237,404.5	51,740.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	319,253.7	483,232.5
2104	Хангамж, бараа материалын зардал	78,922.5	82,790.6
2105	Нормативт зардал	148,899.1	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,505.9	5,263.2
2107	Томилолт, зочны зардал	2,476.0	3,083.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,046.5	54,922.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,912.2	45,634.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	925,947.2	69,025.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	454,334.9	391,024.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	205,195.4	377,647.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	205,195.4	377,647.8
2200	Дотоод эх үүсвэрээр	205,195.4	377,647.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-205,195.4	-377,647.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-195,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	195,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	249,139.5	-181,623.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	99,676.8	348,816.3

**Архангай аймгийн Хайрхан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	348,816.3	167,192.6
----	---	-----------	-----------

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,173,222.8	7,173,222.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,173,222.8	7,173,222.8
9	Тайлант үеийн үр дүн	341,515.1	341,515.1
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,514,737.9	7,514,737.9
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,514,737.9	7,514,737.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-58,024.8	-58,024.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,456,713.1	7,456,713.1
19	Тайлант үеийн үр дүн	-4,652,327.3	-4,652,327.3
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,804,385.8	2,804,385.8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,073,976.8	1,560,686.2	513,290.6	75.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,171,370.3	1,007,388.2	163,982.1	86.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,128,194.7	964,217.6	163,977.1	85.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,224.4	350,537.1	22,687.3	93.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,652.7	43,918.6	2,734.1	94.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	603,871.4	475,858.3	128,013.1	78.8
2104	Хангамж, бараа материалын зардал	24,155.7	23,568.6	587.1	97.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,933.4	5,263.2	670.2	88.7
2107	Томилолт, зочны зардал	3,200.0	3,083.2	116.8	96.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,057.1	36,795.2	6,261.9	85.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,100.0	25,193.4	2,906.6	89.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,175.6	43,170.6	5.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,175.6	43,170.6	5.0	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	541,881.5	358,298.0	183,583.5	66.1

**Архангай аймгийн Хайрхан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	360,725.0	195,000.0	165,725.0	54.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,073,976.8	1,364,987.5	708,989.3	65.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,543,430.7	1,260,112.1	283,318.6	81.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	530,546.1	104,875.4	425,670.7	19.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		332,022.8	(332,022.8)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		114,714.9	(114,714.9)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	63	63		100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	63	63		100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,162.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,162.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,476.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,476.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,440.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,245.6
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,245.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,281.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,281.0
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	2,881.7

#### 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,413.2 мянган төгрөгийн алдаа илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд: Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд зээлийн авлагыг 1,413.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залруулав.

Аудитаар залруулагдаагүй нийт 201,301.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүлжээ.

##### 4.1 Албан шаардлага

4.1.1 Хоршоо хөгжүүлэх санд 16 зээлдэгчтэй холбоотой 40,796.0 мянган төгрөгийн 2-11 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

4.1.2 Сумын төсвийн орлогын гүйцэтгэл 8 нэр төрлөөр буюу малын тоо толгойн албан татварыг 140,309.7 мянга, улсын тэмдэгтийн хураамж тэмдэгтийн хураамж 1,068.5 мянга, шууд бус орлого 393.2 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4,194.8 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 391.9 мянга, бууны албан татвар 780.0 мянга, амьтны нөөц ашигласны төлбөр 162.0 мянга, төсөвт газрын өөрийн орлого 6,205.0 мянган төгрөгөөр нийт 153,505.1 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-т “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

4.1.3 Хайрхан сумын ОНХС-аас сумын засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “Хайрханы ирээдүй дэд хөтөлбөрт зардал гаргах тухай” А/180 дугаар захирамжийн дагуу тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх гэрээг Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-тай байгуулан 7,000,000 төгрөг шилжүүлсэн байна. Сумын засаг дарга нь Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын захирлыг томилдог эрх бүхий албан тушаалтан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хайрхан сумын ТТЗ	1	1413.2			1	1413.2	1	1413.2	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хайрхан сумын ТТЗ	3	201301.1	0	0	3	201301.1	0	0	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Хайрхан сумын ТТЗ	1	0	0	0	1	0	0	0				